



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 0/457

Алтай хот

Үнэлгээний хороог шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Соёл амралтын хүрээлэнг тохижуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: С.Байгальмаа -Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: Т.Болд -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Г.Ундрам -Төрийн бус байгууллагын төлөөлөл

П.Буян-Өлзий -Есөнбулаг сумын иргэн

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж, батлуулан худалдан авах ажиллагааг хариуцлагатай, хууль журмын дагуу зохион байгуулж, дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (С.Байгальмаа)-нд үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гаргасантай холбогдуулан 2020 оны А/42 болон 2020 оны А/391 дүгээр захирамжуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ